

**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЛАБОРАТОРИ  
23 ДУГААР СУРГУУЛЬ**



**МАТЕМАТИКИЙН БАГШ П.БАТ-ОЧИРЫН  
2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН**

2019-06-03

**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР СУРГУУЛИЙН  
МАТЕМАТИКИЙН БАГШ П.БАТОЧИРЫН 2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**I. Төлөвшил**

1. Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал:
  - a) “Замд гарья “ хөтөлбөрт оролцлоо Зохион байгуулсан огноо - 15/IX
  - b) Намрын “Багш нарын буухиа” тэмцээнд оролцож багаараа III байр эзэлж хүрэл медаль авсан . Зохион байгуулсан огноо - 28/IX
  - c) Монголын багш нарын 49 дахь өдөрт Биеийн тамирын секцийн хамт олонтой хамтарч амжилттай зохион байгууллаа Зохион байгуулсан огноо - 5/X
  - d) “Моодле “ сургалт анд хамрагдлаа Зохион байгуулсан огноо - 7/XI
  - e) Математикийн багш нарын их сорилго уралдаанд МАЗАНЫ багш нарын хамт амжилттай бэлтгэж оролцлоо Зохион байгуулсан огноо - 01/IX
  - f) “Эрүүл мэнд инээмсэглэл аян” сургуулиас зохион байгуулсан арга хэмжээнд оролцлоо . Зохион байгуулсан огноо - 4/XII
  - g) “Цэнэглэх цаг” Луужин стратеги “ Зохион байгуулсан огноо – 17/X, “Эрүүл мэнд гоо сайхан” Зохион байгуулсан огноо - 03/XII, “Өсвөр үеийнхний дээрлэхэлт” Зохион байгуулсан огноо - 22/II, “Авилгаггүй ил тод орчин ” Зохион байгуулсан огноо - 25/III , “Багш нарын 7-р их хурлын мэдээлэл” Зохион байгуулсан огноо -22/IX
  - h) Жижүүр багшийн үүрэг гүйцэтгэсэн хугацаа: Оролцсон хугацаа 22/X, 7/XI, 07/XII, Нийт 6 удаа
  
2. Дэгийн хэрэгжилт, Дадал хэвшил суусан байдал:

Ордог ангийн сурагчид багшийг ороход хүндэтгэлтэйгээр мэндлэх, хичээлийн үед гар утас хэрэглэхгүй байх математикийн хичээлээс өөр зүйл хийх, хоорондоо хичээлийн бус агуулгатай зүйл ярихгүй байх зэрэг дадал хэвшилд сургасан Хичээлийн эхнээс 8в 9а ангийн хичээлийн сурагчдын эмх замбараагүй байдлыг горимонд оруулах шаардлагаар байсныг хэвшүүлэсэн
  
3. Бусадтай харилцах байдал : МАЗАН ы багш нартайгаа хамтарч хичээл сургалтын болон өөрийгөө хөгжүүлэх тал дээр хамтарч ажиллаа.

Онцгойлон өнгөрсөн намар болсон Чингэлтэй дүүргийн багш нарын сорилго уралдаанд хамтран бэлтгэж амжилттай оролцсон нь бидний харилцан ойлголцол хамтарч ажиллах байдлыг дээшлүүллээ.. Зураг № 1
  
4. Бусад заах аргын нэгдлүүдийн багш нартай “Моодл программ” ын хэрэгжилтэн дээр хамтарч ажиллаж харилцан суралцаж байна.

Лхамдулам, Ариунзул , Хатанцэцэг нарын залуу багш нараас “Мүүдл” программд нэгж хичээлийн агуулга оруулах , шалгалтын асуулт оруулах зэрэг гол гол ойлголтуудыг аалгаж хэрэглэж сурсан
  
5. Сурагчдын оролцооны ур чадварын хөгжил, дадал хэвшил зан чанарын байдал : Нийт сурагчид 9а ангиас бусад нь Багшид хандах хандлага нь эерэг сайн ,сурч мэдэхийн төлөө хичээнгүй ажилладаг, Хичээлийн явцад багшийн хичээлд төвөг чирэгдэл учруулдаггүй. Гэрийн даалгавар бие дххлтыг цаг тухайд нь биелүүдэг.Хичээлийн оролцоо нь сайжирсан сурагчдаас дурьвал 9е ангиас Ч Анун , Занабазар 8Б Оргилсайхан Бат-Оргил 8в Оюундарь, Анарболд Чинзориг, 8г Ангиас Б Амен Чулууудай Золбоо, Хун Че Ёон нар болно

9А ангийн хувьд багшид тоомжиргүй ханддаг Хичээл дээр байнга хоорондоо ярьдаг зуршилтай гэрийн даалгаврыг бие биенээсээ хуулж , шалгалтын үед хэн нэгнээс хуулж аргацаан өнгөрүүлдэг муу зуршилтай.

Байнга ярьдаг хүмүүсээс дурьдвал Н Хүслэн , Ангийн дарга Марал, Бат-Очир Шинэ Оргил нар

6. Жижүүр багшийн үнэлгээ: 2018.11.07 -ны өдөр бага боловсролын Ц.Нанжидтай багш жижүүр багш хийн хариуцлагатай жижүүр З.Тунгалаг менежер 80% үнэлсэн. 2018 12 .07 -ны өдөр багш Т. Одмаагийн хамт жижүүр багш хийн хариуцлагатай жижүүр М.Цогзолмаа менежер 90% үнэлсэн.
7. 2018 03 .19 -ны өдөр багш Л Эрдэнбаатрын . хамт жижүүр багш хийн хариуцлагатай жижүүр Ш.Оюунсүрэн менежер 100% үнэлсэн. 2019 04-16 -ны өдөр багш Т. Одмаагийн хамт жижүүр багш хийн хариуцлагатай жижүүр М.Цогзолмаа менежер 90% үнэлсэн.

1. Хэдэн судалгаа хийсэн, ямар үр дүнд хүрсэн эсэх, ажилласан байдал :

8. Дадлага удирдах ажлын үр дүн :

9. Эцэг эхийн оролцоо, хичээлээс гадуурх хүмүүжлийн ажлын үр дүн :

10. 7.7 Гадаад хэлний баярын тоглолтыг хоёр өдрийн турш зохион байгуулалтанд ажиллаж дэмжлээ.

11. Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийн биелэлт.

12. Гранд дизайны зорилго зорилтын биелэлт : 1. Хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаанд тэгш хамруулсан. 2. Зөв дадал хэвшилд уриалсан санал зөвлөмжөөр хангасан. 3. Зөв хандлагат чиглүүлсэн сонирхол өрнөхүйц мэдээ мэдээллээр ханган ажилласан. 3. Багаар болон бие даан асуудал шийдвэрлэх ур ухаанд хөтөлсөн. 4. Цагийг үр дүнтэй ,зөв хуваарилалттай ажиллаж сурахад ХГҮА-ны цагийг төлөвлөсөн.


13. Мэдлэг чадвар ахиц, амжилт

1. Гарааны болон Оношлох үнэлгээ : Гарааны үнэлгээг хичээлийн жилийн эхэнд анги бүрээс авсан Оношлох үнэлгээг Улирал бүрд 3-4 удаа авч дүн гаргахад 30 % хувиар тооцдог.


#### 2018-2019 оны хичээлийн жилийн гарааны үнэлгээ

№	Анги, бүлэг	Дүгнэгдсэн	I	II	III	IV	V	VI	VII	VIII	Нийт
1	8б	39	8	0	1	4	6	2	6	12	
2	8в	58	5	4	3	5	8	6	12	15	
3	8г	45	2	1	2	7	5	7	11	10	
Нийт		142	15	5	6	16	19	15	29	37	
3	9а	48	10	8	7	2	5	3	8	5	
4	9е	33	5	6	2	0	6	5	6	3	
Нийт		81	15	14	9	2	11	8	14	8	
Бүгд		223	30	19	15	18	30	23	43	45	

#### 2018-2019 оны хичээлийн жилийн 8-р ангиудын гарааны үнэлгээ



## 2018-2019 оны хичээлийн жилийн 9-р ангиудын гарааны үнэлгээ



### Гарааны үнэлгээнд хийсэн ерөнхий дүгнэлт

2. 8, 9- р ангиудын гарааны үнэлгээний дүнг харьцуулсан байдлаас харвал дараах дүгнэлт гарч байна 8б, 8в, 8г ангиуд гарааны үнэлгээнд хангалттай сайн дүн үзүүлсэн байна. Энэ нь сургалтын агуулгыг өмнөх ангид заасан багш нь сурагчдад тохирсон арга хэрэглэн заасан, сурагчид сурах үүргээ ухамсарлан чармайлт гаргаж сурсаний холбоотой гэж үзэж байна. Гэхдээ дүнгийн тархалтаас үзвэл сайн сурагчид олон тааруу сурагчид ч цөөнгүй, дундаж дүнтэй сурагчид олон байгаа нь зөв биш тархалт юм. Даалгавар бага зэрэг хөнгөдсөн байх магадгүй юм.
3. 9-р ангиудын хувьд жигд тархалттай байгаа нь тааруухан дүр зураг юм
4. 1-3-р түвшний сурагчид нийт сурагчдын 35% байгаа нь цаашид анхаарч ажиллах асуудал мөн.
5. 6-8-р түвшний сурагчид нийт сурагчдын 43% байгаа нь сайн дүр зураг
6. Ерөнхийдөө шалгалтын дүн сурагчдын сурлагын бодит байдалтай ойролцоо гарсан байна
7. Улирал бүрийн нэгж хичээлийн боловсруулалт /MOODLE/ 1. 3-р улиралд 5 нэгж 2. 4-р улиралд 6 нэгж боловсруулан СА-р батлуулан Мүүдлд оруулсан.
8. Стандарт хэрэгжилт
9. Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлт : 1.Шинээр хэрэгжүүлж буй Мүүдл системийг эзэмшиж байгаа. 2..Зааж буй бүлгийн сурах бичгийн судалгаа, бодолтыг хийх зорилгоо 100% биелүүлсэн. 3 Залуу багш нарыг аливааг цаг хугацаанд нь бүрэн гүйцэтгэж сурахад чиглүүлэх, үлгэрлэн үзүүлэх, дагуулан сургах үйлийн зорилгоо биелүүлж байгаа. 6. Цэнэглэх цаг бүрийн үр ашигтай зөвлөмж, санааг тусган хэрэгжүүлж байгаа.
10. Судлагдахууны хөтөлбөрийн үр дүн : 8б, 8в, 8г 9а, 9е ангийн 220 сурагчид хөтөлбөр төлөвлөсөн дагуу хүргэлээ. Нийт 140 цагийн агуулга хүргэх байснаас сүүлийн уурван долоо хоног шалгалтын үе байсан тул хөтөлбөрийг нягтаршуулан НБГ-ын “Даалгаврын сан”-ийн бодлогоор орлуулан дуусгав.
11. Журнал бичилт: Цаг тухай бүрд нь 1. Хичээлийн үйл ажилагааг анги бүрд хэрхэн зохион байгуулсан юу нь болов, юуг анхаарах талаар дэлгэрэнгүй дүгнэлт хийсэн. 2. Багшийн тэмдэглэл хэсэгт сурагчдыг ажиллуулах арга ,заавар зөвөлгөө болон гимнастик хийлтийг / анги бүрд / бичин цаг тухайд нь дүгнүүлж байсан.

12. Хичээлд ордог сурагчдын хүртээмж: 8-р ангийн гурав, 9-р ангийн 2 бүлэг нийт 220 сурагчид хичээл орж байна. Хичээлээ хөтөлбөрт тусгасны дагуу ангид багштай хамтарч гүйцэтгэх, сурагч бие даан гүйцэтгэх, гэрт гүйцэтгэх бие даалтын ажил, сэдвийн үнэлгээ гэсэн хэсгүүдээр сурагчдад үзсэн агуулгыг нь эзэмшүүлж байна.

Сурагчдын гэрийн даалгаврын гүйцэтгэл болон , сэдвийн үнэлгээ, дэвтрийн ажиллагаа , хичээлийн үед биеэ авч явах байдлыг тусгасан Үнэлгээний самбарыг анги тус бүрд улирал бүрээр нь бүртгэж , сургалтын алба болоод сонирхсон хүмүүст нээлттэйгээр үзүүлж байна эцэг эхийн нээлттэй хаалганы өдрөөр эцэг эхчүүдэд танилцуулсан.

13. Багшийн хөгжлийн дэвтрийн хөтлөлт: БХД-н үзүүлэлт бүрээр, өдөр тутам хийх ажил болон хийгдсэн хамрагдсанг дэлгэрэнгүй бичиж СА-аар дүгнүүлж байсан


14. Хүүхэд бүрийн ахиц амжилтанд нөлөөлсөн бүтээлч ажил:

Сурагчдад нэгж бүрээр нь ажлын хуудас бэлдэж үзсэн агуулга , бататгал хичээл, бие даалт зэрэг сурагчдын сурлагын ахиц амжилтыг дэмжих чиглэлийн бүхий л зүйлийг оруулсан .Энэ нь хичээлийн агуулгаа цагт нь ойлгоогүй сурагчдад дахин давтах, богино хугацаанд үзсэн агуулгыг нөхөж ойлгоход тустай зүйл болсон Жишээ болгож 8-ангийн Хавсралт №1


**2018-2019 оны хичээлийн жилийн эцсийн үнэлгээ**

<input type="checkbox"/>	Анги, бүлэг	Дүгнэгдсэн	I	II	III	IV	V	VI	VII	VIII	Нийт
1	8б	40	0	0	0	0	0	8	18	14	
2	8в	54	0	0	0	1	1	10	23	18	
<input type="checkbox"/>	8г	44	0	0	0	0	2	7	16	19	
<b>Нийт</b>		<b>138</b>									
3	9а	48	0	0	0	0	0	1	20	26	
4	9е	32	0	0	0	0	0	2	20	10	
<b>Нийт</b>		<b>80</b>									
<b>Бүгд</b>		<b>218</b>									

**2018-2019оны хичээлийн жилийн 8-р ангиудын жилийн эцсийн үнэлгээ**



**2018-2019 оны хичээлийн жилийн 9-р ангиудын  
жилийн эцсийн үнэлгээ**



**Жилийн эцсийн үнэлгээнд хийсэн ерөнхий дүгнэлт**

Хичээлийн жилийн эцсийн улиралд цаг цөөн боловч үзэх агуулга их, үзсэн агуулгыг бүрэн эзэмшүүлэхэд нэмэлт цаг давтлага хэрэгтэй боловч аль аль нь боломжоор хомс, сурагч нэг бүртэй тулж ажиллах хэрэгтэй байгаа ч багшид тийм цаг зав мөн л ховор байдалтай байлаа.

Миний хувьд дээрх асуудлын заримыг нь шийдэх үүднээс хичээлээс гадуур хоцрогдол арилгах давтлагыг өгч байна.

Үр дүн нь хамрагдсан сурагчдын ахиц, сургалтыг дэмжсэн эцэг эхийн сэтгэл ханамжийн байдлаар харагдаж байна

## **II. Авьяасыг нээн судлах хөгжүүлэх**

Сонирхлын судалгаа англи хэлний

2. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлсэн байдал /Улс нийслэл, дүүрэг, сургууль/ 1.Ордог ангийн сурагчдаас математикийн хичээлээр үзүүлсэн амжилтаас дурдвал 86 ангийн Х Номин дүүргийн уралдаанд оролцсон.
3. Олимпиад уралдаан тэмцээн : 1. Математикийн цаг сэтгүүлийн нэрэмжит стандарт олимпиадад „8в ангийн Чинзориг 1-р байр, Хавар 5-р байр, 9а Маралгуа 9-р байр Чоймпэл 11-р байр тус тус эзэлсэн. 2. Сэтгэх чадварын сургуулийн олимпиадад 8б Х.Номин топ үнэлгээ үзүүлсэн.
4. Бүтээлч шинэлэг ажил болж чадсан.
5. Хүүхэд нэг бүрийн оролцоог хангаж анги нийтээрээ хөгжсөн байдал : Хүүхэд нэг бүрийн хичээлийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор сурагч нэг бүрийн хийж гүйцэтгэх бие даалтын даалгавар бэлтгэж өгсөн 8-р ангийн хувьд Ц.Хасбаатрын сургалтын материалаас мөн шалгалтанд бэлтгэхэд зориулсан тестийн сан гийн бодлогоноос бэлтгэв
6. Багш ажлын байран дээрээ хөгжсөн байдал : 1. Мүүдл системийн сургалтыг тухай бүрд нь эзэмшиж нэг хөтөлбөр оруулах,эцэг эх болон сурагчдад даалгавар,мэдээлэл өгөх ,ангийн танилцуулга бичлэг хийн байршуулах, “Бар” код авах,бар кодоор мэдээлэл авах зэрэгт суралцсан.  
2.Цахим хэрэглэгдэхүүнтэй хичээл явуулж сурсан. 3. Бие бялдарын сорилд нормт үзүүлэлтийг гүйцэтгэх бэлтгэл ханган сорилыг 16 оноотой “В” үнэлгээтэй өгсөн 4.

### **Боловсролын сэтгэл ханамж**

1. Цаг ашиглалт : 1. Дэвтэртэй ажиллах, даалгаврыг нэгбүрчлэн шалгах 2. Журналт бичилт хийх 3. Багшийн хөгжлийн дэвтэр хөтлөх 4. Хичээл заах 5. Цаг үеийн хурал ,цуглаанд хамрагдах 6. Ангиа тараах 7. Ангиа цэвэрлүүлэх 7. Хяналтын ажил засах 8. Олимпиад уралдаан тэмцээн явуулах, засах 8. Анги болон сурагчдаа үйл ажиллагаанд бэлдэх 9. Цаг үеийн сургуулийн үйл ажиллагаанд оролцох 9. Багш нарын хичээлд суух,хэлэлцүүлэх зохион багуулах 10. Сурагчдад эерэг болон хэрэгцээт сургалт /танхимын бус/ явуулах 11. Хүүхдийн сурах эрүүл ,аюулгүй орчин бүрдүүлэх 12.Эцэг эхийн хурал зохион байгуулах, судалгаа авах 13. Мүүдлийн сургалтанд хамрагдах 14. Сурагчдыг хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамруулан үзвэр үйлчилгээ үзүүлэх,сэтгэгдэл бичүүлэх 15.Жижүүр багш хийх 16.6-р ангийн бүлгийн ажил ,хуралд хамрагдах 17.ЗАН-ийн хурал болон цаг үеийн ажилд хамрагдах 18. Ангийн эд аж ахуйн эвдрал засах, будах шинэчлэх 19. Ангиа шалгалт шүүлэгт бэлдэх 20. Нэгжийн болон улирлын шалгалт авч засах дүнг оруулах 21. Сурагч бүрийн хувийн хэрэгтэй танилцан хөтлөлт хийх 22. Ямар нэг судалгаа авч нэгтгэх,явуулах 23. Дадлага удирдах ,сургах, дадлагын хэлэцүүлэг хийх 24. Төгсөгч сурагчидтай харилцах ,тодорхойлолт бичих,гэдэнд үйлчлэх
2. Сэтгэл ханамжийн судалгаа : 1. Эцэг эхээс сургуулийн үйл ажиллагааны сэтгэл ханамжийн судалгаа авч бүлгээр нэгтгэн -2Хичээлийн цагийн хариуцлага-40 минут : Яг цагтаа хичээлийг эхлүүлж эхлээд гэрийн даалгаврын ойлгоогүй бодлоготой ажиллан шинэ хичээлээ заан өөрийн үнэлгээг хийлгэж заншсан. Мөн ангийн чадварт тохируулан гэрийн даалгавар өгөх, санамж зөвөлгөө, гимнастик хийлгэх зэрэг 40 минцтыг алдагдалгүй ашиглаж байлаа.
3. Багшийн ёс зүй, хууль эрх зүйн биелэлт : Тухайн анги ,сурагчдын нас биений онцлог зан аашны өөрчлөлтийг ШУ-ны үүднээс судалж тохирсон аргаар нь харьцан ёс зүйг дээдлэн сэтгэл ханамжтай ажиллалаа.
4. Багшийн хичээлийн бэлтгэл : 1. Улирал бүрийн нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулан СА-р батлуулж байсан. Нийт 11 нэгж батлуулсан. 2. Мүүдл системд 11 нэгж хөтөлбөрөө оруулсан. 3.Амралтын даалгавар боловсруулан өгч сурагч нэг бүрийн амралтын даалгаврыг шалган эцэг эхэд нь мэдээлсэн. 4. Цөм хөтөлбөрийн ном болон 8-р ангийн багшийн номыг бүрэн ашигласан. 8-р ангийн сурах бичгийн бодолт бүрэн хийж алдаатай болон заах аргын зөвөлгөөг багш Б.Лхамдуламтай хэлэл цэн ангийн онцлогийн харгалзан ажиллаж ирлээ. 5. Нэг бүлэгт 2-3 багш орохдоо нэгнийхээ боловсруулсан

хөтөлбөр, төлөвлөгөөг хамтран хэлэлцэж сайжруулах, туршин заах, хэлэлцүүлэгт хичээл явуулах зэрэг ажил хийгдэж байгаа нь заах арга зүйн хувьд хамтаараа сайжрах боломжтой болсон

5. Хоцрогч таслагч сурагчидтай ажилласан байдал хүрсэн үр дүн :

8-р ангийн сурагчдын хувьд Математикийн хичээлд хандах хандлага эерэг сайн, хичээл таслалт хоцролт багатай, хичээлийн агуулгын хоцрогодолтой сурагчдыг нэмэлт цагаар хичээлээс гадуур датлага өгөх, тэргүүлэгч сурагчдад хариуцуулах зэрэг ажил зохион байгуулсны хүчин зарим сурагчдын сурглаганд ахиц гарлаа.

6. Багш сургалтын ажлын баримт бичгийг зохих журмын дагуу хөтөлж байгаа байдал :  
1. Багшийн журналыг бүрэн бичилт хийж 2. Анги журналыг үзүүлэлт бүрээр 3. Багшийн хөгжлийн дэвтрийг өдөр тутам хөтлөн 4. Сурагчийн хувийн хэргийн зөв хөтлөлтийг шалган дутууг гүйцээх зэргийг заагдсан хугацаа бүрд нь сургалтын албаар үнэлүүлж хэвшсэн.
7. Сургалтын техник хэрэгслийг ашигласан байдал : 1. Өөрийн нөөтбүүк дээр шаардлагатай программ ашиглан боловсруулалт хийж сурсан. 2. Канонийг бүрэн ажиллуулан шалгалтын материалаа хүссэн хэмжээ, тоогоор олшруулан ашиглаж сурсан. 3. Ангийн зурагтыг HDM оролтоор холбон ээлжит хичээлд болон “Мүүдэл”-ээс хэрэгтэй материалаа татан “Цахим” орчин үүсгэн хэрэглэж сурсан.
8. Сурагчдын хөгжил төлөвшил эрсдэлийн судалгааны сан бүрдэлт : 1. Цагаар хичээл таслах 2. Ангийн болон бүлгийн атаман болох хүсэл энэ насанд төрдөг 3. Эцэг эх бага ангийн багш шиг өдөр тутам багш нартай харьцдаггүй болохоор худлаа хэлэх, хийлүүдэх 4. Цахим орчин, тоглоомонд дурлан өглөө гэрээсээ эрт гарч тоглож байгаад хичээлээс хоцрох зэрэг жижиг боловч орхигдуулж болохгүй даруйд нь засаж байх шаардлагатай зөрчил, дутагдал гардаг.  
Эцэг эхтэй нь утсаар болон биечлэн уулзаж асуудлыг шийдвэрлэж байлаа..
9. Хяналтын хуудасны хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийсэн байдал : Аливаа үйл ажиллагаа болгоны араас ямар хэмжээнд оролцов?, үйл ажиллагааг бүрэн дуусгаж чадсан уу?, юуг дутуу хийв?, яаж хэрхэн хэнд хүргэх асуултыг өөртөө тавьдаг.

### **Ш. Эрүүл мэнд**

1. Мэндлэх хүндлэх –Зөв боловсон харилцаа : 8-9 –р ангийнхан бусадтай ялангуяа багш нартай байнга мэдэлж заншсан.  
Багшийг ээлжит хичээл заахаар орж ирэхэд 8в 9а анги хүндэтгэлгүй ханддаг байсныг засч залруулсан
2. Эрүүл мэндийн анхан шатны дадал хэвшилд сургаж үлгэрлэсэн байдал : а). Дөрөвдүгээр цагийн завсарлагаанаар хичээл орж буй ангитайгаа гимнастик хийж хэвшсэн. б) Зөв суух дадалд хичээл ордог ангийн сурагчдыг зөв суухын ашиг тусыг ШУ-ны үндсийг таниулан зөвлөн хичээл бүр дээр сануулан ажиллаж байна. в) Ангийн сурагчдыг улирал бүр салаа хооронд байрлалыг солих, өдөр бүр урагш ахих замаар байрыг солин харааны нэг өнцөг тогтохоос сэргийлэн ажиллаж байна.
3. Эрүүл мэндийн сургалт зохион байгуулж гарсан үр дүн: 9е 9а ангид сүрьеэ өвчин нийгмийн халдварт өвчин болох талаар ярьж өгсөн
4. Анги танхимын цэвэр эмх цэгцтэй байдалд сургаж хэвшүүлсэн байдал :  
8в 9 а анги хичээл ороход ширээ сандал нь хайш яйш, бүгчим, агаар муутай байдаг байсныг хичээлийн жилийн эхнээс хэлж засуулж хэвшүүлсэн.
7. Жижүүр сурагчдын үйл ажиллагаа жигд ажиллагаатай эсэх : .
8. Анги танхимын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтын талаар зөв ойлголт өгч, тэдгээртэй зөв харилцах дадал хэвшилд сургасан байдал
9. Эрүүл мэндийн үзлэг, сургалт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар хийж хэрэгжүүлсэн байдал
10. Ангийн ариун цэвэр эрүүл мэндийн булангийн хэрэгжилт
11. Эрүүл шүд-Эрүүл хүүхэд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд хийсэн ажил :

Тайлан бичсэн :

П.Бат- Очир



Зураг №1 Математикийн багш П.Бат-Очир , С Цэнгэлмаа, Б.Лхамдулам нар багш нарын “ ИХ СОРИЛГО “ уралдаанд бэлтгэж бодлого бодож байгаа нь

**Хавсралт №2**

**Ажлын хуудас №1**

**Сэдэв : Шугаман тэнцэтгэлбиш**

**Хамрах хүрээ 8-р анги 11-12/II**

**Хичээл № 1-2**

**Багштай хамтарч**

- 1) Бат 3 аас бага тоо санав
  - a) Математик бичиглэлээр бич
  - b) Геометр дүрслэлээр илэрхийл
  - c) Тоон завсар хэлбэрээр бич
- 2) Бат 5 аас их тоо санав
- 3) Бат 8 Багагүй тоо санав
- 4) Бат -7 ихгүй тоо санав  
Дээрх гурван бичиглэлээр бич

**Сурагчид бие даан ажиллах**

- 5) Бат 17 аас бага тоо санав
  - d) Математик бичиглэлээр бич
  - e) Геометр дүрслэлээр илэрхийл
  - f) Тоон завсар хэлбэрээр бич
- 6) Бат 8 аас их тоо санав
- 7) Бат 4 Багагүй тоо санав
- 8) Бат -6 ихгүй тоо санав Дээрх гурван бичиглэлээр бич

**Багштай хамтарч**

- 1) Шугаман тэнцэтгэлбишийг бод
  - a)  $x > 3$
  - b)  $x > -2$
  - c)  $x > 0$
- 2) Шугаман тэнцэтгэлбишийг бод
  - d)  $2x > 4$
  - e)  $2x > -2$
  - f)  $-3x < 12$
- 3) Шугаман тэнцэтгэлбишийг бод
  - g)  $2x + 2 \geq 6$

h)  $3x - 1 \geq 5$

i)  $-2x \leq 3$

4) Шугаман тэнцэтгэлбишийг бод

j)  $2(x - 3) > 8$

k)  $-3(x + 2) \leq 9$

l)  $2(3 - x) < -8$

**Сурагчид бие даан ажиллах**

Шугаман тэнцэтгэлбишийг бод

m)  $x > 6$

n)  $x > -4$

o)  $x > 0$

5) Шугаман тэнцэтгэлбишийг бод

p)  $2x > 12$

q)  $2x > -4$

r)  $-3x < 9$

6) Шугаман тэнцэтгэлбишийг бод

s)  $3x + 2 \geq 8$

t)  $2x - 1 \geq 5$

u)  $-2x \leq 7$

7) Шугаман тэнцэтгэлбишийг бод

v)  $2(x - 2) > 10$

w)  $-3(x + 1) \leq 12$

x)  $2(3 - x) < -14$

**Багштай хамтарч**

Шугаман тэнцэтгэлбишийг бод

y)  $x \leq 7$

z)  $x < -3$

aa)  $x \leq 0$

8) Шугаман тэнцэтгэлбишийг бод

bb)  $4x \leq 4$

cc)  $2x \leq -6$

dd)  $-3x \geq 15$

9) Шугаман тэнцэтгэлбишийг бод

ee)  $2x + 7 \leq 9$

$$ff) 3x - 1 \geq 8$$

$$gg) -2x + 1 < -3$$

10) Шугаман тэнцэтгэлбишийг бод

$$hh) 2(x - 3) \leq -8$$

$$ii) -3(x + 2) < 9$$

$$jj) 2(3 - x) \geq x + 3$$

$$kk) 5x + 12 \leq 3x + 6$$

$$ll) -3x + 12 \leq 4x + 5$$

Бие даалт №1 Сурах бичгийн хуудас 70-72

Бодлого № 53-57